



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ**



## **АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ**

**Салбар:**

**Зам тээвэр**

**Мэргэжлийн нэр:**

**Авто зам, гүүрийн барилгын ажилтан**

**Улаанбаатар хот**

**2018 он**

**Ажил мэргэжлийн лавлах: Авто зам, гүүрийн барилгын ажилтан**

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулав.

ISBN:

**Ажил мэргэжлийн лавлахын баталгаажилт**

Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт (YAMAT 08)-ын код:	7116-18
Хөтөлбөрийн индекс: Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал (ISCED-13 ):	Зам барих 0732-608
Баталсан байгууллага, огноо:	МБСУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоол
Баталгаажуулсан байгууллага, огноо:	Монголын Авто Замчдын Холбоо 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр
Хянан засварласан хувилбар, огноо	№ 01 ..... оны ... дугаар сарын .... ны өдөр
Хянан засварлах хугацаа	Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн тогтоож, өөрчлөлт орох эсвэл шаардлагатай тохиолдол бүрт
Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан аргачлал	ДАКУМ шинжилгээний аргачлал

Энэхүү ажил мэргэжлийн лавлахыг ХНХЯ-ны зөвшөөрөлгүйгээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

## АГУУЛГА

	Хуудасны дугаар
Өмнөх үг	3
Товчилсон үгийн тайлбар	4
1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ	5
2. Ажлын байрны товч тодорхойлолт	6
3. Ажлын байрны тухай мэдээлэл	6
3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл	
3.2 Ажлын байранд тавигдах шаардлага	
3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт	
3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал	
4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл	7
5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил	8
5.1 Мэдлэг	
5.2 Ур чадвар	
5.3 Хандлага, төлөвшил	
6. Үүрэг ба ажилбарын жагсаалт	9
7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо	12
8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл	12
9. Авто зам, гүүрийн барилгын ажилтан мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл	13

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Авто зам, гүүрийн барилгын ажилтан” мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг боловсруулав.

Мэргэжлийн боловсрол, сургалтад оролцогч талууд төрийн байгууллага, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, ажил хайгч, оюутан, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан бөгөөд лавлахыг хэн хэрхэн ямар хэрэгцээнд зориулан ашиглаж болохыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- төрийн байгууллага хөдөлмөр эрхлэлт, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэхэд;
- ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам боловсруулахад;
- политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, түүнчлэн холбогдох их, дээд сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө боловсруулах, төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, багш нарыг сургаж бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэхэд;
- ажил хайгч иргэд, суралцагчид нь ажлын байрны хэрэгцээ шаардлага, түүнд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлага төлөвшил, хөдөлмөрийн нөхцлийн талаарх мэдээллийг олж авахад ажил мэргэжлийн лавлахыг ашиглаж болно.

Ажил мэргэжлийн лавлах нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно.

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, хийж гүйцэтгэх үүрэг, ажилбарыг салбарын зөвлөх, мэргэжилтэн, томоохон аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн багш нарын мэдлэг, туршлагад тулгуурлан ажил мэргэжлийн дүн шинжилгээний ДАКУМ арга зүйгээр боловсруулсан.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бодитоор нийцэж, төр, хувийн хэвшлийн түншлэл, шинэ техник технологи, шинэлэг арга зүйд тулгуурлан хөгжих болтугай.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСБХЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМЛ	Ажил мэргэжлийн лавлах
АМДШ	Ажил мэргэжлийн дүн шинжилгээ
АХБ	Азийн хөгжлийн банк
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл
МБССЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын салбар зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ХЭУЧД төсөл	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл

## 1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ

Энэхүү ажил мэргэжлийн лавлах нь ажлын байранд тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно. Уг лавлагаас дараах хэрэглэгчид шаардлагатай мэдээллийг олж авна. Үүнд:

Хэрэглэгч	Лавлагаас авах мэдээлэл
<b>Төрийн байгууллага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний болон салбар, бүс, орон нутгийн түвшинд тодорхойлж боловсруулах;</li> <li>• Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах, ажлын байр, хөдөлмөрийн харилцааг зохицуулах асуудалтай холбогдох мэдээллийг авах;</li> <li>• Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтны ур чадварыг үнэлэх;</li> <li>• Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зорилгоор ашиглах.</li> </ul>
<b>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон Политехник коллеж</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажил олгогчийн шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах;</li> <li>• Тухайн мэргэжлийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, багшийг сургаж бэлтгэх;</li> <li>• Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх;</li> <li>• Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, үйлдвэрлэлийн дадлагыг хамтран зохион байгуулах.</li> </ul>
<b>Ажил олгогч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын байрны тодорхойлолт, ажилтан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулах;</li> <li>• Ажилтныг үнэлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг үнэлэх, цалинг тогтоох;</li> <li>• Ажлын ачаалал, нормыг тогтоох;</li> <li>• Ажилтныг давтан сургах, мэргэшүүлэхтэй холбогдсон сургалтын хэрэгцээг тодорхойлох, захиалгат сургалтыг төлөвлөх;</li> <li>• Сургалтын байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>• Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дээрх дадлагажуулах сургалтыг зохион байгуулах.</li> </ul>
<b>Иргэн ба ажил хайгч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын байрны нөхцөл, тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл авах;</li> <li>• Ажлын байранд гүйцэтгэх үндсэн үүрэг, ажилбар, ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн талаар мэдээлэл авах;</li> <li>• Мэргэжлийнхээ хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн талаар ойлголт авах;</li> <li>• Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай мэдээлэл авах;</li> <li>• Ажлын байр, аж ахуйн нэгж байгууллагын талаар мэдээлэл авах.</li> </ul>

## 2. Ажлын байрны товч тодорхойлолт

Авто зам, гүүрийн барилгын ажилтан нь зам, гүүрийн байгууламжийн талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөж, газар шорооны ажил, суурь хучилтын ажлыг гүйцэтгэх, гүүр, хиймэл байгууламж байгуулах, явган замын болон тоноглолын ажлыг хийх, авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлыг талбайн инженер, даамал, техникчдийн зааварчилгаа, удирдлага дор болон бие дааж гүйцэтгэнэ.

## 3. Ажлын байрны тухай мэдээлэл

### 3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл

- Авто зам, гүүрийн барилгын ажилтан нь авто зам, гүүрийн барилга, хиймэл байгууламжийн талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан орчин нөхцөлд ажиллана.
- Авто зам, гүүрийн барилгын ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.
- Авто зам, гүүрийн барилгын ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон норм, нормативын дагуу явуулна.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, зааварчилгаа болон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан нөхцөлд ажиллана.
- Авто зам, гүүрийн барилгын ажилтан нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдана.
- Авто зам, гүүрийн барилгын ажилтан нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллах бөгөөд хуулийн дагуу тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгох боломжтой.

### 3.2 Ажлын байранд тавигдах шаардлага

- Авто зам, гүүрийн барилгын ажилтан мэргэжлийн боловсролтой, 18 нас хүрсэн иргэн байна.

### 3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт

- Мэргэжлийн үнэмлэхтэй байна. Зарим тохиолдолд чадамжийн гэрчилгээ шаардагдаж болно.

### 3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал

- **Машин механизм:** Авто ачигч, автогрейдер, асфальт дэвсэгч, бетон дэвсэгч, булт индүү, бульдозер, кран, бетон зуурагч, өөрөө буулгагч машин, дахин боловсруулагч машин, үйлчилгээний автомашин, усны машин, хийн дугуйт индүү, экскаватор гэх мэт.
- **Тоног төхөөрөмж:** Арматур матагч, асфальт зүсэгч хөрөө, битумын тогоо, будаг халаагч, бутлуур, гагнуурын аппарат, гар нягтруулагч, дрилл, компрессор, нивелир, олс, өрөм, теодолит, тэмдэглэгээ хийх машин, тэргэнцэр, уртасгагч, хэв хашмал, цахилгаан үүсгүүр гэх мэт.
- **Багаж хэрэгсэл:** Алх, арматур боох дэгээ, арматур тасдагч, аюулгүй ажиллагааны тэмдэг, багс, бахь, бээлий, гадас, гар доргиур, гар нягтруулагч, гар чийдэн, гэрэл ойлгогч, жоотуу, зүсвэрийн хөрөө, лантуу, лоом, малтуур, метр, мэдээлэх тэмдэг,

ниви, резинэн алх, рейк, тасдагч, , туузан ойлгогч лент, тэгш ус, усны сав, хадаас, хайч, хамгаалах бүс, харандаа, хөдөлмөр хамгааллын хувцас, хөдөлмөр хамгааллын бүрэн хэрэгсэл, хөрөө, хувин, хучлагын бүтээлэг, хүрз, цахилгаан өрөм, чиг тавих утас, шуудай, шүүр гэх мэт.

- **Түүхий эд, материал:** Арматур, асфальт бетон хольц, бетон, битум, будаг, буталсан чулуу, буталсан элс, бэхжүүлэгч материал, ойлгогчтой будаг, тэмдэглэгээний шохой, ус, уулын чулуу, хавтан, хадаас, хайрга, хашлага, хэв хашмал, цавуу, цайруулагч, цемент, цемент бетон, цэгэн утас, чулуу, элс, эрдэс нунтаг, шороо, төмөр утас гэх мэт.
- **ХАБЭА-н хэрэгсэл:** ХАБЭА-н шаардлагын дагуу анхны тусламжийн иж бүрдэл болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

#### 4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл

Ажлын байранд дараах хууль, дүрэм журам, стандартыг баримтална. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- MNS 5080:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
- MNS 4994:2000 Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS12.1.016:88 Хэт өндөр дуу, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
- MNS AASHTO M86M:2005 Бетон суваг, үерийн ус зайлуулах хоолой, техникийн шаардлага
- MNS AASHTO M17M:2005 Нүхтэй төмөр бетон хоолой, техникийн шаардлага
- MNS 4699:99 Явган зам, талбайн хавтан
- MNS ASTM E1778:2006 Авто замын хучилтын эвдрэлтэй холбоотой нэр томъёо ба тайлбар
- MNS 1593:2002 Авто замын хучилтын хавтан, техникийн шаардлага
- MNS 4912:2016 Авто замын тэмдэг болон дохионы төмөрбетон шон, техникийн шаардлага
- MNS 4912:2016 Зам талбайн хучилтын бетон хавтан, техникийн шаардлага
- MNS 4597:2013 Замын тэмдэг, тэмдэглэл, техникийн шаардлага.
- MNS EN12966:2016 Шон суурьтай замын тэмдэг, замын гэрэлтдэг тэмдэг
- MNS 5614:2016 Авто замын төмөр хашлага, техникийн шаардлага
- MNS 6567:2015 Авто замын асфальтбетон хучилтыг дахин боловсруулах, техникийн шаардлага
- MNS 6517:2015 Авто замын хаалт, техникийн ерөнхий шаардлага
- MNS AASHTO 45:2004 Авто замд хэрэглэх зориулалтаар хөрс, хөрс-хайрган хольцыг ангилах. Техникийн шаардлага
- MNS AASHTO M 57:2004 Замын далангийн дэвсгэр үе ба далангийн материал. Техникийн шаардлага
- БНБД 21-01-02 Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал



- БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга
- БНБД 31-03-03 Эрүүл ахуйн норматив
- БНБД 33БНБД 22-004-2016 Авто зам төсөллөх
- БНБД 32.02.12 Авто замын гүүр ба хоолой төсөллөх
- БНБД 32.02.00 Авто зам барих

## **5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил**

### **5.1 Мэдлэг**

- М 1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журам, стандарт
- М 2. Байгууллагын дотоод дүрэм, журам
- М 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага
- М 4. Авто зам, замын байгууламжийн ерөнхий ойлголт
- М 5. Гүүр, хиймэл байгууламжийн тухай ерөнхий ойлголт
- М 6. Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын тухай ерөнхий ойлголт

### **5.2 Ур чадвар**

- УЧ 1. Ажлын болон заводын схем зургийг унших, схемийн дагуу ажлын гүйцэтгэлийг төлөвлөх
- УЧ 2. Ажлын зураг, схемийн дагуу угсрах
- УЧ 3. Хэмжилтийн үед рейктэй ажиллах
- УЧ 4. Даланг хэлбэржүүлэх
- УЧ 5. Дээжийг зөөвөрлөж хүлээлгэн өгөх
- УЧ 6. Том болон овор ихтэй чулуун материалтай болгоомжтой ажиллах
- УЧ 7. Үйлдвэрлэлийн бааз байгуулах үеийн ажлыг гүйцэтгэх
- УЧ 8. Бүс бетон хийх, цементийн зуурмагийг орц, нормын дагуу зуурах
- УЧ 9. Хэв хашмал угсрах
- УЧ 10. Гадсыг бэлтгэх

### **5.3 Хандлага, төлөвшил**

- Х 1. Мэргэжилдээ дуртай байх
- Х 2. Багаар ажиллах чадвартай, хамтач байх
- Х 3. Бусдыг сонсдог, харилцааны соёл, ажлын байрны ёс зүйг сахидаг байх
- Х 4. Ажилдаа бүтээлчээр ханддаг, санаачлагатай байх
- Х 5. Ажлын хариуцлагатай байж цаг баримталдаг байх
- Х 6. Хөдөлмөрийн сахилгатай байх
- Х 7. Хувийн зохион байгуулалт сайтай байх

## **6. Үүрэг ба ажилбарын жагсаалт**

Авто зам, гүүрийн барилгын ажилтны хийж гүйцэтгэх ажил үүргийг ажилбараар ангилан тодорхойлов. Мэргэжлийн боловсрол, сургалтаар олгох боломжгүй дадлага ажлыг ажлын байрны бодит орчинд хийж гүйцэтгэх шаардлагатай ажилбаруудыг (\*) тэмдэглэгээтэй үзүүлэв.


Д/д	Үүрэг	Ажилбар
1	Авто зам, гүүрийн бэлтгэл ажил хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийх*</li> <li>- Түр ажлын байр барих*</li> <li>- Үйлдвэрлэлийн бааз байгуулах</li> <li>- Хэмжилтийн ажилд оролцох*</li> <li>- Талбайн цэвэрлэгээ хийх*</li> <li>- Шороон орд нээх</li> <li>- Шороон ордыг нөхөн сэргээх</li> </ul>
2	Авто зам, гүүрийн газар шорооны ажил хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Механизмын операторыг дохиx*</li> <li>- Ул хөрсний цэвэрлэгээ хийх*</li> <li>- Далангийн материал буулгуулах*</li> <li>- Ирсэн материал бүртгэх*</li> <li>- Ирсэн механизмыг бүртгэх*</li> <li>- Том чулууг түүх*</li> </ul>
3	Авто замын ус зайлуулах хоолой барих	<ul style="list-style-type: none"> <li>- Хоолойн суурийн ухмалд тэгшилгээ хийх</li> <li>- Хоолойн суурийн ул хөрсийг нягтруулах</li> <li>- Буталсан чулуун суурь хийх</li> <li>- Хэв хашмалыг угсрах</li> <li>- Арматурын хэлхээс зангидах</li> <li>- Суурийн бетон цутгах</li> <li>- Суурийн бетон арчлах</li> <li>- Хоолойн цагираг өрөх</li> <li>- Дугуй хоолойн залгаас хэсгийг чигжих</li> <li>- Дугуй хоолойн бүс бетон цутгах</li> <li>- Дугуй хоолойн тулц бетон цутгах</li> <li>- Дөрвөлжин хоолойн их биеийн арматур зангидах</li> <li>- Дөрвөлжин хоолойн их биеийн хэвийг бэхлэх</li> <li>- Их биеийн бетон цутгах</li> <li>- Толгойн далавчны хэв хашмал хийх</li> <li>- Толгойн далавчны арматур зангидах</li> <li>- Толгойн далавчны бетон цутгах</li> <li>- Ус тусгаарлах үе хийх</li> <li>- Хоолойн амсрын чулуун бэхэлгээ хийх</li> </ul>
4	Авто зам, гүүрийн ус зайлуулах суваг байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хэмжилтийн ажилд оролцох</li> <li>- Ухмалын гар тэгшилгээ хийх*</li> <li>- Шуудуунд чулуун бэхэлгээ хийх</li> <li>- Шуудуунд бетон бэхэлгээ хийх</li> <li>- Бэхэлгээгүй шуудууг засах</li> <li>- Лоткины ул суурь тэгшлэх</li> <li>- Лоткины ул бетон цутгах</li> <li>- Лоткины угсралт хийх</li> <li>- Лоткины худаг хийх</li> <li>- Лоткины залгаасыг чигжих</li> <li>- Буцаан дүүргэлт хийх</li> </ul>

5	Гүүрийн байгууламж барих	<ul style="list-style-type: none"> <li>- Хэмжилтийн ажилд оролцох</li> <li>- Суулгах худгийн ажилд оролцох</li> <li>- Тулгуурын хэв хашмал зангидах</li> <li>- Тулгуурын арматур зангидах</li> <li>- Буцаан дүүргэлт хийх</li> <li>- Ригель насадок барих</li> <li>- Тулах хэсэг суурилуулах</li> <li>- Алгаслалын бүтээц угсрах</li> <li>- Ус зайлуулах цорго хийх</li> <li>- Хэв гажилтын заадас суурилуулах</li> <li>- Аюулгүйн хашлага барих</li> <li>- Зорчих хэсгийн бетон цутгах</li> <li>- Дамжих хавтан хийх</li> <li>- Явган зам барих</li> <li>- Заслын ажил хийх</li> <li>- Урсгал чиглүүлэх далан барих</li> <li>- Эргийн тулгуурыг бэхлэх</li> <li>- Завсрын тулгуурт бэхэлгээ хийх</li> <li>- Талбайн цэвэрлэгээ хийх</li> </ul>
6	Авто замын хучилтын суурь үе барих	<ul style="list-style-type: none"> <li>- Хэмжилтийн ажилд оролцох</li> <li>- Суурийн материалыг буулгуулах*</li> <li>- Ирсэн материалыг бүртгэх*</li> <li>- Ирсэн механизмыг бүртгэх*</li> <li>- Том чулууг түүх*</li> <li>- Цементийг талбайд буулгах*</li> <li>- Цементийг задалж тараах*</li> <li>- Гараар тэгшилгээ хийх</li> </ul>
7	Авто зам, гүүрийн явган замын ажлыг хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Хэмжилтийн ажилд оролцох</li> <li>- Хашлаганы суурь ухах</li> <li>- Хашлаганы дэвсгэр үе хийх</li> <li>- Ул бетон цутгах</li> <li>- Замын хашлага угсрах</li> <li>- Манаас бетон хийх</li> <li>- Хашлага хоорондын гагнаас хийх</li> <li>- Явган замын суурь бэлтгэх</li> <li>- Явган замын суурь нягтруулах</li> <li>- Явган замын хавтан суурилуулах</li> <li>- Элсэн чигжээс хийх</li> </ul>
8	Авто замын хучлага хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Хэмжилтийн ажилд оролцох</li> <li>- Суурийн цэвэрлэгээ хийх*</li> <li>- Битумын цацлага хийх</li> <li>- Асфальт бетон хольцыг тэгшлэх</li> <li>- Хучлагын ирмэг залгаасыг нягтруулах</li> <li>- Асфальт хучлаганы залгаасыг хөрөөдөх</li> <li>- Залгаас хэсэгт битум түрхлэг хийх</li> </ul>

9	Авто замын хөвөө байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Дүүргэлтийн материал буулгуулах*</li> <li>- Дүүргэлтийн материалыг тэгшлэх*</li> <li>- Том чулууг түүх*</li> <li>- Хөвөөг гараар нягтруулах*</li> <li>- Далангийн хажуу налууг хэлбэржүүлэх</li> <li>- Далангийн хажуу налууд бэхэлгээ хийх</li> </ul>
10	Авто зам, гүүрийн тоноглолын ажил хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Зорчих хэсгийн тэнхлэгийг тэмдэглэхэд оролцох*</li> <li>- Замын цэвэрлэгээ хийх*</li> <li>- Хэвтээ тэмдэглэгээ хийхэд оролцох</li> <li>- Босоо тэмдгийн суурийн нүх ухах</li> <li>- Босоо тэмдгийг суулгах</li> <li>- Тэмдэгний шон бэхлэх</li> <li>- Замын цэвэрлэгээ хийх</li> </ul>
11	Авто зам, гүүрийн засвар арчлалтыг хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр тутмын цэвэрлэгээ хийх*</li> <li>- Эвдрэлийн судалгаа хийхэд оролцох*</li> <li>- Мэдээлэх тэмдэг байрлуулах</li> <li>- Засварлах нүхийг ухах</li> <li>- Хучилтанд нөхөөс хийх</li> <li>- Хагарлын гагнаас хийх</li> <li>- Хөвөөг нөхөн сэргээх</li> <li>- Далангийн хажуу налууг засах</li> <li>- Хоолойн цэвэрлэгээ хийх</li> <li>- Хоолойн эвдрэл засварлах</li> <li>- Суваг шуудууг сэргээн засварлах</li> <li>- Өвлийн замын арчлалт хийх</li> <li>- Гүүрийн арчлалт хийх</li> <li>- Чулуун бэхэлгээ сэргээх</li> <li>- Урсгал чиглүүлэх далан засварлах</li> <li>- Гүүрийн эвдрэл засварлах</li> </ul>
12	Өөрийгөө хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Багаар ажиллах чадварыг хөгжүүлэх</li> <li>- Илтгэх ур чадварыг хөгжүүлэх</li> <li>- Мэргэжлийн зэрэг ахиулах*</li> <li>- Боловсролын түвшин ахиулах*</li> <li>- Шинэ техник судлах</li> <li>- Шинэ технологи судлах</li> <li>- Туршлага солилцох</li> <li>- Мэргэжлийн гадаад хэлээ сайжруулах*</li> </ul>

## 7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо

Авто зам, гүүрийн барилгын ажилтны бусад албан тушаалтантай ажиллах уялдаа холбоог дараах байдлаар дүрслэн харуулав.



Тухайн ажилтныг удирдах албан тушаал болон удирдуулан ажиллах ажилтныг босоо тэнхлэгээр харуулж байгаа бөгөөд энэ нь түүний өсч, дэвших боломжийг мөн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, авто зам, гүүрийн барилгын ажилтан нь авто замын техникчийн удирдлага, хяналтан дор ажиллаж, замчин буюу туслах ажилтныг удирдан, хэвтээ тэнхлэгт байрлах ажилтнуудтай хамтран ажиллана.

## 8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл

Иргэн тухайн мэргэжлээр суралцах эсвэл ажил хайж байгаа тохиолдолд дараах мэдээлэлтэй танилцаж, сонголтоо хийх боломжтой.

Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын мэдээлэл	Ажил олгогч байгууллагуудын мэдээлэл
<p>Тухайн мэргэжлээр бэлтгэдэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон политехник коллежийн талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p><a href="http://www.asc.mn">http://www.asc.mn</a></p>	<p>Тухайн мэргэжлээр ажилтан хайж байгаа байгууллагуудын талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p><a href="http://hudulmur-halamj.gov.mn/job/list">http://hudulmur-halamj.gov.mn/job/list</a></p>

## 9. Авто зам, гүүрийн барилгын ажилтан мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл

### Ажил мэргэжлийн лавлахын ДАКУМ шинжилгээг боловсруулахад оролцсон багийн гишүүд:

- |                  |  |
|------------------|--|
| 1. Э.Энхбат      | “Наранбулагхан” ХХК-ийн Замчин                   |
| 2. С.Долгорсүрэн | “Дайргант” ХХК-ийн Зөвлөх инженер                |
| 3. С.Эрдэнэцэцэг | “Дайргант” ХХК-ийн Зам, гүүрийн ажилтан          |
| 4. Д.Батмөнх     | “Арж роуд” ХХК-ийн Замчин                        |
| 5. С.Болдбаатар  | “Тэргүүн саруул зам” ХХК-ийн Зам гүүрийн ажилтан |
| 6. Ж.Бямбасүрэн  | “SRP Mongolia” ХХК-ийн Зам гүүрийн ажилтан       |
| 7. Б.Энхбат      | “SRP Mongolia” ХХК-ийн Гүүрийн инженер           |
| 8. С.Сүхтулга    | “Монголын хурдны зам” ХХК-ийн Замчин             |
| 9. Х.Цэрэндэндэв | “Заабар” ХХК-ийн Замчин                          |
| 10. Ц.Цогнэмэх   | “Замын битум” ХХК-ийн Замчин                     |

### Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг баталгаажуулсан:

- |                   |   |
|-------------------|---|
| 1. Б.Барамсай     | “Наранбулаг Хан” ХХК-ийн Замчин           |
| 2. П.Ганхүү       | “Наранбулаг Хан” ХХК-ийн Замчин           |
| 3. Ч.Хишигтогтох  | “Дайргант” ХХК-ийн Даамал                 |
| 4. Б.Нэргүй       | “Дайргант” ХХК-ийн Замчин                 |
| 5. Н.Түвшинтулга  | “Арж Роуд” ХХК-ийн Техникч                |
| 6. Ч.Базаррагчаа  | “Арж Роуд” ХХК-ийн Даамал                 |
| 7. Н.Бүрэнтөгс    | “Тэргүүн саруул зам” ХХК-ийн Замчин       |
| 8. Х.Бямбадорж    | “Тэргүүн саруул зам” ХХК-ийн Замчин       |
| 9. Н.Ууганболд    | “SRP” ХХК-ийн Гүүрийн техникч             |
| 10. С.Баттулга    | “SRP” ХХК-ийн Гүүрийн техникч             |
| 11. Б.Доржготов   | “УБ Зам засвар арчлалтын газар”-ын Замчин |
| 12. Н.Батболд     | “SRP” ХХК-ийн Замчин                      |
| 13. Н.Анхмандах   | “Монголын хурдны зам” ХХК-ийн Замчин      |
| 14. Д.Энх-амгалан | “Монголын хурдны зам” ХХК-ийн Замчин      |
| 15. Д.Ганбат      | “Заабар” ХХК-ийн Замчин                   |
| 16. Б.Цолмондаваа | “Заабар” ХХК-ийн Замчин                   |
| 17. Н.Даваабат    | “Замын битум” ХХК-ийн Замчин              |
| 18. Г.Баярцэнгэл  | “Замын битум” ХХК-ийн Замчин              |

**Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг хянасан авто замын салбарын экспертүүдийн төлөөлөл:**

1. И.Гончигзэвэг Монголын Авто Замчдын Холбооны Сургалт, арга зүйн зөвлөлийн дарга, Монгол Улсын Зөвлөх инженер
2. Ч.Лхагважав Монголын Авто Замчдын Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, “ЛАБО” ХХК-ийн инженер, Монгол Улсын Зөвлөх инженер, Доктор
3. Ч.Долгорсүрэн Монголын Авто Замчдын Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, ТТДС-ийн Авто замын тэнхимийн эрхлэгч, Монгол Улсын Зөвлөх инженер

**Ажил мэргэжлийн дүн шинжилгээний чиглүүлэгчид:**

1. Ц.Мөнхнаран ДАКУМ II зэргийн гэрчилгээт Сургагч багш
2. Д.Энхтуяа ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, МАЗХ-ны Сургалтын менежер
3. Д.Эрдэнэбат ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, ХХҮЕГ-ийн Мэргэжлийн болон техникийн боловсролын агуулга, арга зүй хариуцсан мэргэжилтэн

**Ажил мэргэжлийн лавлахын загварыг боловсруулж, хянасан зөвлөхүүд:**

1. Д.Адилбиш ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн
2. Ц.Ганчимэг АХБ-ны ХЭУЧД төслийн ЧССҮ-ний мэргэжилтэн
3. Д.Энхбаатар ЧССҮ-ний Үндэсний зөвлөх
4. Г.Батчимэг ЧССҮ-ний Зөвлөх

10. Авто зам, гүүрийн барилгын ажилтан мэргэжлийн үүрэг, ажилбарын зураглал (ДАКУМ шинжилгээ)

ҮҮРЭГ

АЖИЛБАР

A	Авто зам, гүүрийн бэлтгэл ажил хийх	A-1 Нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийх AAB	A-2 Түр ажлын байр барих ABB	A-3 Үйлдвэрлэлийн бааз байгуулах AAB	A-4 Хэмжилтийн ажилд оролцох AAA	A-5 Талбайн цэвэрлэгээ хийх BAA	A-6 Шороон орд нээх AAB	A-7 Шороон ордыг нөхөн сэргээх AAB												
	B	Авто зам, гүүрийн газар шорооны ажил хийх	B-1 Механизмын операторыг дохиу BCA	B-2 Ул хөрсний цэвэрлэгээ хийх BAA	B-3 Далангийн материал буулгуулах ABA	B-4 Ирсэн материал бүртгэх BCA	B-5 Ирсэн механизмыг бүртгэх BCA	B-6 Том чулууг түүх BAA												
C	Авто замын ус зайлуулах хоолой барих	C-1 Хоолойн суурийн ухмалд тэгшилгээ хийх BAA	C-2 Хоолойн суурийн ул хөрсийг нягтруулах ABA	C-3 Буталсан чулуун суурь хийх AAA	C-4 Хэв хашмалыг угсрах AAA	C-5 Арматурын хэлхээс зангидах AAA	C-6 Суурийн бетон цутгах AAA	C-7 Суурийн бетон арчлах ABA	C-8 Хоолойн цагираг өрөх BAA	C-9 Дугуй хоолойн залгаас хэсгийг чигжих BBA	C-10 Дугуй хоолойн бүс бетон цутгах BBA	C-11 Дугуй хоолойн тулц бетон цутгах BBA	C-12 Дөрвөлжин хоолойн их биеийн арматур зангидах AAA	C-13 Дөрвөлжин хоолойн их биеийн хэвийг бэхлэх AAA	C-14 Их биеийн бетон цутгах AAA	C-15 Толгойн далавчны хэв хашмал хийх BAA	C-16 Толгойн далавчны арматур зангидах AAA	C-17 Толгойн далавчны бетон цутгах AAA	C-18 Ус тусгаарлах үе хийх BBA	C-19 Хоолойн амсрын чулуун бэхлэгээ хийх ABA
D	Авто зам, гүүрийн ус зайлуулах суваг байгуулах	D-1 Хэмжилтийн ажилд оролцох AAA	D-2 Ухмалын гар тэгшилгээ хийх BAA	D-3 Чулуун бэхлэгээг шуудуунд хийх BAA	D-4 Бетон бэхлэгээг шуудуунд хийх BBA	D-5 Бэхлэгээг үй шуудууг засах CCA	D-6 Лоткины ул суурь тэгшлэх ABA	D-7 Лоткины ул бетон цутгах BAA	D-8 Лоткины угсралт хийх AAA	D-9 Лоткины худаг хийх AAA	D-10 Лоткины залгаасыг чигжих BBA	D-11 Буцаан дүүргэлт хийх AAA								
E	Гүүрийн байгууламж барих	E-1 Хэмжилтийн ажилд оролцох AAA	E-2 Суулгах худгийн ажилд оролцох AAA	E-3 Тулгуурын хэв хашмал зангидах AAA	E-4 Тулгуурын арматур зангидах AAA	E-5 Буцаан дүүргэлт хийх AAA	E-6 Ригель насадок барих AAA	E-7 Тулах хэсэг суурилуулах AAA	E-8 Алгаслалын бүтээц угсрах AAA	E-9 Усзайлуулах цорго хийх AAA	E-10 Хэв гажилтын заадас суурилуулах AAA	E-11 Аюулгүйн хашлага барих AAA	E-12 Зорчих хэсгийн бетон цутгах AAA	E-13 Дамжих хавтан хийх AAA	E-14 Явган зам барих AAA	E-15 Заслын ажил хийх AAA	E-16 Урсгал чиглүүлэх далан барих AAA	E-17 Эргийн тулгуурыг бэхлэх AAA	E-18 Завсрын тулгуурт бэхлэгээ хийх AAA	E-19 Талбайн цэвэрлэгээ хийх CBA
F	Авто замын хучилтын суурь үе барих	F-1 Хэмжилтийн ажилд оролцох AAA	F-2 Суурийн материалыг буулгуулах BBA	F-3 Ирсэн материалыг бүртгэх BCA	F-4 Ирсэн механизмыг бүртгэх BCA	F-5 Том чулууг түүх BAA	F-6 Цементийг талбайд буулгах BAA	F-7 Цементийг задалж тараах AAA	F-8 Гараар тэгшилгээ хийх AAA											
G	Авто зам, гүүрийн явган замын ажлыг хийх	G-1 Хэмжилтийн ажилд оролцох AAA	G-2 Хашлаганы суурь ухах BAA	G-3 Хашлаганы дэвсгэр үе хийх ABA	G-4 Ул бетон цутгах ABA	G-5 Замын хашлага угсрах AAA	G-6 Манаас бетон хийх BBA	G-7 Хашлага хоорондын гагнаас хийх AAA	G-8 Явган замын суурь бэлтгэх BAA	G-9 Явган замын суурь нягтруулах ABA	G-10 Явган замын хавтан суурилуулах AAA	G-11 Элсэн чигжээс хийх BCA								
H	Авто замын хучлага хийх	H-1 Хэмжилтийн ажилд оролцох AAA	H-2 Суурийн цэвэрлэгээ хийх AAA	H-3 Битумийн цацлага хийх ABA	H-4 Асфальт бетон хольцыг тэгшлэх AAA	H-5 Хучлагын ирмэг залгаасыг нягтруулах AAA	H-6 Асфальт хучлаганы залгаасыг хөрөөдөх AAA	H-7 Залгаас хэсэгт битум түрхлэг хийх AAA												
I	Авто замын хөвөө байгуулах	I-1 Дүүргэлтийн материал буулгуулах BBA	I-2 Дүүргэлтийн материалыг тэгшлэх AAA	I-3 Том чулууг түүх BBA	I-4 Хөвөөг гараар нягтруулах ABA	I-5 Далангийн хажуу налуугхэл-бэржүүлэх AAA	I-6 Далангийн хажуу налууд бэхлэгээ хийх AAA													
J	Авто зам, гүүрийн тоноглолын ажил хийх	J-1 Зорчих хэсгийн тэнхлэгийг тэмдэглэхэд оролцох AAA	J-2 Замын цэвэрлэгээ хийх ABA	J-3 Хэвтээ тэмдэглэгээ хийхэд оролцох AAA	J-4 Босоо тэмдэгийн суурийн нүх ухах AAA	J-5 Босоо тэмдэгийг суулгах AAA	J-6 Тэмдэгний шон бэхлэх BBB	J-7 Замын цэвэрлэгээ хийх ABA												
K	Авто зам, гүүрийн засвар арчлалтыг хийх	K-1 Өдөр тутмын цэвэрлэгээ хийх AAA	K-2 Эвдрэлийн судалгаа хийхэд оролцох AAB	K-3 Мэдээлэх тэмдэг байрлуулах ABA	K-4 Засварлах нүхийг ухах ABA	K-5 Хучилтанд нөхөөс хийх AAA	K-6 Хагарлын гагнаас хийх AAB	K-7 Хөвөөг нөхөн сэргээх AAA	K-8 Далангийн хажуу налууг засах AAA	K-9 Хоолойн цэвэрлэгээ хийх AAB	K-10 Хоолойн эвдрэл засварлах AAB	K-11 Суваг шуудууг сэргээн засварлах AAB	K-12 Шуурхай ажлын хэсэгт ажиллах AAA	K-13 Замын цас мөс цэвэрлэх AAA	K-14 Халтиргаанаас хамгаалах материал цацах AAA	K-15 Гүүрийн арчлалт хийх AAA	K-16 Чулуун бэхлэгээс эргээх AAB	K-17 Урсгал чиглүүлэх далан засварлах AAB	K-18 Гүүрийн эвдрэл засварлах AAA	
L	Өөрийгөө хөгжүүлэх	L-1 Багаар ажиллах чадварыг хөгжүүлэх AAA	L-2 Илтгэх үр чадварыг хөгжүүлэх AAA	L-3 Мэргэжлийн зэрэг ахиулах AAC	L-4 Боловсролын түвшин ахиулах AAC	L-5 Шинэ техник судлах ABB	L-6 Шинэ технологи судлах ABB	L-7 Туршлага солилцох ABA	L-8 Мэргэжлийн гадаад хэлээ сайжруулах AAC											

ТЭМДЭГЛЭЛ: Саарал өнгөтэй хэсэгт ажлын байран дээр ирэхээс өмнө сургалтын байгууллагаар олгох ажилбарыг заасан бөгөөд үүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгад заавал тусгана. Цагаан толгойн гурван үсгийн дарааллаар чухал, хүнд, давтамжийн үзүүлэлтүүдийн харьцангуй түвшинг илэрхийлдэг. Ингэхдээ эхний үсэг нь чухлын зэргийг (А-маш чухал, В-чухал, С-чухал биш), хоёр дахь үсэг нь ажилбарын хүндрэлийн түвшинг (А-маш хүнд, В-хүнд, С-хүнд биш), гурав дахь үсэг нь ажилбарыг гүйцэтгэх давтамжийг (А-байнга, В-заримдаа, С-ховор) илэрхийлнэ. Жишээлбэл: Ажилбарыг ABC гэж тэмдэглэсэн бол тухайн ажилбар нь маш чухал, хүнд, ховор гүйцэтгэдэг ажилбар гэсэн утгатай.